

Олон Улсын Харилцааны Дээд Сургууль

АЛТАН АРСГАМЖ

АЛТАН АРСГАМЖ

VOL.3

1/2000

ЧИНГИС ХААН БА ХОРЕЗМ (САРТУУЛ)-ЫН ЭЛЧИН ХАРИЛЦААНЫ ТҮҮХЭЭС.

*МУИС, НУФ, Түүхийн тэнхимийн багш
д/д-р, дэд проф. Д.Хүүхэнбаатар*

Нэгдсэн Монгол улс (1206) байгуулагдсанаар түүний гадаад харилцаанд эрс өөрчлөлт гарч өрнө дорнын өргөн уудам газар, улс орнууд, харийн шашинтай харьцах явдал гарч ирсэн юм.

Чингис гадаад бодлогодоо энэ бүхнийг маш нарийн бодож боловсруулсан байсан учир нэгээхэн ч зүйлд тулгамдах явдал гараагүй.

Чингис хаан гадаад бодлогынхоо үндсийг зэргэлдээх Хятад, Хорезм, Тайчад, улмаар дэлхийн бусад орнуудаар Монгол улсын тусгаар тогтнолыг зөвшөөрүүлэх, найрамдалт харилцаа тогтоох явдал гэж үзсэн бөгөөд хэрэгжүүлэх бодитой алхамууд хийсэн билээ.

Чингис хааны Хорезмын шах Мухамедэд явуулсан элчээр хэлгүүлсэн үгэнд "...Миний туйлын хүслэн бол чамтай найрамдалтай байхыг хүснэ". ... Бидэнд ойр дөт хязгаар нутгийг дайснаас цэвэрлэж, нэгэнтээ байлдан дагуулж хоёр эгтээдээс хөршийн эрхийг тодорхойлсон (эдүгээ) цагт тал талаасаа харилцан зохицох арга зам сүвэгчилэхийг оюун санаа, буян сэтгэл шаардаж буй тул бид зовлон бэрхтэй зүйлд бие биенээ тэтгэн туслах хийгээд бас ч энэ хорвоогийн олонхийн аялгаас шалтгаалах учир тэднийг амар мэнд явуулахын тулд зам харууг аюулгүй байлгах, гэнэтийн гамшигаас сэрэмжлэх үүрэг авцгаавал (чингэвэл) бидний хооронд тогтсон зөвшилдөөний үрд (сэтгэлийн түгшүүр) үл тайвшрахын шалтаг арилж, цуугих болон үл дагах үйлсийн дэмжлэг тасрах буй" гэжээ.

Энэ нь Чингисийн төрийн гадаад бодлогоо найрамдал хэмээн тодорхойлж, улс хоорондын харилцааг нээх, найрамдахад хамгийн гол хэрэглүүр бол худалдааны харилцаа гэдгийг тэрээр эн тэргүүнээ ойлгосон хүн байлаа.

Түүний хамт Чингис хаан Зөрчидийн Алтан улстай байлдаж байх үедээ Хятадыг эзлэж авах түүний газар нутагт шүнасан Хорезмын шахын дараагийн алхамд хориг тавих дипломат бодлого бөгөөд бас өөрийн сүр хүчийг илтгэн, сурдүүлэх ихэмсэг бардан аястай далд санаагаа ч илэрхийлсэн байна.

Тэрээр "Би чамайг нэн хайрт хөвүүн мэт үэнэ", "миний орон шоргоолж мэт олон цэрэгтэй, мөнгөний уурхай мэт баялаг, над бусдын эрхшээлд өнгөлзөх хэрэг байхгүй" гэсэнээс тодорхой байдаг.

"Нэн хайрт хөвүүн" гэсэн нь өөрөөсөө доромж үзэж өөрийн хараат гэдэг санааг хэлэхийн хамт өөрийнхөө сүр хүчин, бардам ихэмсэгийг сурдүүлэх аястай илэрхийлжээ.

Чингис 1206 онд Монголын эзэнт улс тогтмогц гадагш дайтахыг гол болгоогүй юм. Тийм ч бодит үндэс, үндэсний сонирхол байгаагүй, галцхуу өөрийн Монгол улсынхаа тусгаар тогтнолыг зөвшөөрүүлэхэд л оршиж байсан.

Зүрчидийн Алтан улстай эхэлсэн дайн нь Алтан улс Монголын тусгаар тогтнолыг үл зөвшөөрөн илэрхий дайсагнасан бодлого явуулж байснаас, мөн хараат байдлаас гарахын төлөөний тэмцэл байлаа.

Чингис хааны гадаад бодлогод Хорезм, улмаар Өрнөдтэй харилцах явдал гол байр суурийг эзэлж тодорхой бодож боловсруулсан бодлоготой байсан нь Хятадын хэрэгт Хорезмыг оролцуулахгүй байх, Хорезмтэй найрамдалт харилцаа барьж, цааш алс Өрнөдөд нэвтрэхийг зорьж байжээ. Ийм учраас Монгол улс Хорезмтой туйлын болгоомжтой, дэс дараалсан бодлого явуулж бас ихээхэн хүлээцтэй хандаж байжээ.

Энэ улс бол газар зүйн байршлын хувьд их торгон зам дайрч өнгөрдөг ойр орчиндоо хүчтэй нэлгээд нөлөө бүхий хүчирхэг Хорезмтой тулгарах нь зайлшгүй гэдгийг тодорхой мэдэж тооцож байжээ. Өрнө зүг рүү дөхөх, алхам алхмаар ойртохын тулд олон талын арга хэмжээнд тайван замаар газар нутгаа тэлж дөхөх, элч төлөөлөгч илгээх худалдаачдыг элчин харилцааны бодлогод өргөн

ашигласан. Хорезмын зарим том ноёдыг талдаа татах нууц холбоо тогтоосон. Өрнөдөд нэвтрэхийн тулд цэргээр хамгаалуулсан элч нарыг илгээж байсан зэргийг хэлж болох юм.

Энэ бүхэнд Чингисийн төрийн "Алтан аргамж"⁴ элчин харилцаа онцгой үүрэг гүйцэтгэсэн юм. Элч нарт эрх хэмжээ, ямба цолыг баталсан алт, мөнгө, хүрэл пайз олгоно. Улмаар Өгөөдэйн үеэс өртөө зам байгуулагдаж эхэлжээ. Элчинг "дуу бариулж", "хэлүүлсэн нь", "үг гэж хэл" гэдэг нь Рашид Ад-диний хэлсэнчлэн "Монголчууд эрт цагаас элчингүүд нь голдуу толгой холбон шүлэглэсэн ёгт уран үгийг цээжээр дамжуулдаг заншилтай"⁶ гэсэнээс нотлогдож байна. Академич Ц.Дамдинсүрэн "Албан бичиг нь их төлөв шүлэг бөгөөд цээжлэвч амархан тул дуу гэж нэрлэсэн мэт"⁷ гэжээ.

Дээрх тайлбарын зөвийг энэ үеийн элчин харилцааны баримтууд (Өлзийт хааны бичиг) батлах бөгөөд тэгэхдээ албан бичгийг голдуу Их гүрний үеэс хэрэглэх болсон.

Цээжлүүлж амаар дамжуулах, дуу бариулах нь бичиг үсэг мэддэггүй байсандаа биш нууцыг чандлах шилмэл арга байжээ. Элчин эс уравбал нууц үл алдагдах билээ. Бас бичиг барин явуулсан ч чухам хэлбэл зохих үг "элчийн аманд бий" гэж тулгар бичгүүдэд дурдсан байдаг. Монголчууд элчийг хүлээж авах тогтсон нарийн журам дэгтэй байсан. Энэ тухай Сүн улсын элчин Зоотуан өөрийн "Монгол-Татарын бүрэн тэмдэглэл" номондоо их хааны элчийг тохиолдсон газар орны эрх баригчид цөмөөр хүндэтгэн өнгөрүүлэх, элчийн зэрэг дэвийн их багыг харгалзахгүй танхимд хүндэт суудалд суулгах, алба хэрэг хэлцэх, хүндэт харуул гаргаж сахиулах, элчийг их хаалганы гадна угтан уулзахдаа хэнгэрэг дэлдэн, хөгжим үүсгэн хиур далбаа барьж жагсаах ёстой байжээ.

Их хаанд элчин бараалхахад төдий л их ёслол гүйцэтгэдэггүй маш шулуун үг үгүүлэх нь тэдний эртний эгэл ёс төр, зан заншил нь эвдрээгүйн тэмдэг гэж ажиглан тэмдэглэжээ. Монголчууд өөрийн ёс журмыг үл дагах аваас их хаанд бараалхуулдаггүй талын дундуур оруулж хүлээн авч Их хааны хөрөгт заавал мөргүүлнэ. Гадаадын элчин бараалхахад хэлмэрч хэргэлдэг, элчинг хүндэтгэн сархалдаар дайлах илдний наадам үзүүлнэ, элчин ёсорхог бус аашлахад дургүйцдэггүй байсан ажээ.

Хорезмтой хиллэн харилцаж эхлэх үед Чингист бүрэн тогтсон,

уян нарийн бодлого, бүтэц бүрэлдсэн байжээ. Гэтэл Хорезм элчин харилцаа гадаад бодлого, Монголтой харилцах талаар туйлын бүүдүүлэг хоцорсон байжээ. Энэ нь харилцааг тайван замаар хөгжүүлэх боломжийг хаан дайнд хүргэсэн билээ.

Нутагаа тэлэх бодлогын гол нь ивгээх, сайн дураар дагаж оруулах хараат болгох явдал. Үүний жишээнд 1207 онд Хиргис, 1209 онд Уйгурууд Чингистэй элч төлөөлөгч солилцож, бэлэг сэлт барьж, ураг барилдаж их улсын өмгөөлөлд багтав.

Нутаг тэлэх бодлогот элчин харилцаа чухал голлох үүрэг гүйцэтгэдэг. "Уйгур болон ... Киргис улсыг байлдаангүй харьяандаа оруулж авсан нь Монголын элчин харилцаа дипломат бодлогын томоохон амжилт гэж тооцогдож байв"⁸ хэмээн залуу эрдэмтэн Ж.Бор зүйтэй дүгнэлт хийсэн байна.

Энэ төрлийн бодлогот хамаарах бодлого бол зэргэлдээх орнуудын дотоод зөрчлийг ашиглах шашны талаарх чөлөөтэй шүтэх бодлого, зарим томоохон ноёдтой нууц харилцаа тогтоож, төлөөний хүмүүсийг ажиллуулж байлаа.

Хар Хятаныг харьяандаа оруулахдаа Найманы Хүчүлэг Хар-хатанд төрийн эрх мэдлийг босогчдын дэмжлэгээр авсан боловч амлалтаасаа няцаж шашны талаар хавчиж лал шашинтны эсэргүүцлийг дахин хүчтэй өрнүүлсэн юм. Хүчүлэг, олон түмнээс христос, буддын шашныг сонгож лалын шашнаас татгалзахыг шаардаж, лал шашинтыг хятад хувцас өмсөхийг албадаж байв. Лал шашинтанд нийгээр хурал хураахыг хоригложээ.

Цэргүүдээ лал шашинт айлуудаар хуваарьлан суулгаж, дарлаж эсэргүүцэл үзүүлсэн. Хатны хамба ламыг сүмийнх нь үлдэнд цовдлон хороох зэргээр харгислаж байжээ. Чингис хаан үүнийг тооцож үзээд 1218 онд Зөв ноёныг 20 мянган цэрэг авахуулан мордуулж "хүн бүр өөрийн шүтдэг шашин шүтлэгээ хэвээр үлдээж эцэг өвгөдийн ёс гуримыг сахиж болно" гэсэн уриа дэвшүүлж орохыг зөвлөсөн байна.⁹

Монголчуудыг ороход кашгар зэрэг газар бослого гарган дэмжиж үлтсэн бөгөөд Хүчүлэг зугатан зайлж яваад алагдсанаар Хар хятан улс Их улсын эрхшээлд дагаж оров.

Чингис хаан өрнө зүгт явуулах бодлогоотоо хорезмыг эсэргүүцэхгүй байлгах, алс өрнө зүгт харах цонх, гарах гарц бий болгохыг онцгой анхаарч байжээ. Энд элчин харилцаанд оруулж

хэлэлцэж болох нэгэн зүйл гол цэрэглэсэн элч¹⁰ билээ. Их хаан Зэв, Сүвээдэй, Тогучар нарыг тус бүрийг түмэн цэрэг авахуулан явуулсан нь байлдан дагуулах их цэрэг биш, өрнийг танин мэдэх, холбоо тогтоох, цонх нээх элчид байсан болуу гэж үзнэ. Хааны захиссанд хорезмын нутаг дэвсгэр, ноёдын эзэмшилд огтхон ч халдаж болохгүй гэсэн хатуу даалгавар өгсөн нь үүнтэй холбоотой. Тэд очсон газар бүртээ элч илгээж харилцаж байсан нь үүнийг нотолно.

Тогучар ноён үүнийг зөрчсөн Учир хүндээр шийтгүүлсэн байдаг. Учир нь Мервийн Мелик Чингисийн нууц холбоотон байсан бололтой. Тэрээр Скелал Ад диний тэмцэл явцгүй болж суларч байгааг ойлгон Чингис хаанд ойртож байсан бололтой. Чингис хааны элчин харилцааны бодлого нь эв найрамдлыг аван явагч, санаачлагч байлаа.

Монгол хорезм (сартуул)-ын хооронд элчин харилцаа үүсэж, хэрхэн явагдсан, эцсийн үр дүнг тоймлон гаргая. Монгол Сартуулын элчин харилцаа 1215 оноос эхэлжээ.¹¹ Худалдааны харилцаа бол үүнээс нэлээд өмнө хөгжиж эхэлжээ. Чингис Мухамед Шахын гол зөрчил нь Хятадын асуудал байв.

Сартуулын хаан Мухамед Долоон мөрний хойт хэсгийг нэгтгэж, Кипчакт амжилттай дайтсаны дараа нутаг нь эдний талаас Монгол гүрний хил хязгаартай ойртож иржээ. Мухамед хятадыг эзлэх гэсэн хэтийн бодлогын үүднээс монголчуудын хүч, бодлого байдлыг тагнан мэдэх явдлыг чухалд үзэх болжээ. Хөгжиж байсан худалдааны харилцааг ашиглан 1215 онд Ходжөндийн Ахмед Хусейн, (Хасан ноёны хүү) Ахмед Балчич нараар толгойлуулан хэсэг худалдаачин-заншлагчдыг илгээсэн байна.¹² Эдгээр худалдаачид хорезмын шахын тусгай явуулсан элч Бека Аддинийг дагалдан очсон¹³ бололтой.

Эдгээр элчийн гол зорилго нь Хятадыг Чингис эзэлсэн нь үнэн эсэх, түүний цэргийн хүчийг тагнан мэдэх нууц зорилготой байв. Гэвч эдгээр элч, худалдаачид нь өнгөндөө найрамдалтай байх зорилгын үүднээс ирсэн мэт байсан бөгөөд үүнийг Чингис хаан дуртай хүлээн авч, хорезмыг хятадын зүг санаархуулахгүй байх бодлогодоо ашиглах аятай даглим гэж үзжээ.¹⁴ Тэгээд ч хоёр улсын хоорондын харилцаа энэхэн үед муудаагүйгээр барахгүй, 1218 онд худалдааны гэрээ байгуулагдажээ. Чингис хаан тэдгээр элчийн

хариу болгон өөрийн элч худалдаачдыг Сартуулд явуулсан байдаг. Элчингүүдийг Султаны харъяат асан Хорезмын Махмуд, Бухьрын Али Ходжа, Отарын Юсуф нараар толгойлуулан явуулсан бөгөөд тэд Сартуулын хаантай улгаж¹⁶ Чингис хааны Сартуулын хаантай найрамдалтай хөршлөн орших хүсэл, худалдаа наймаа хийх аюулгүй байдлыг хоёр талаасаа хангах, бие биедээ ирж очилцох хэвийн харилцааг хөгжүүлэх тухай үгийг дамжуулж, дээр дурьдсан худалдааны гэрээ байгуулагдажээ. Элчийн аманд явуулсан илгээлтээ Чингис хаан өөрийн баримтлах бодлогыг илэрхийлэн гаргасныг дээр нэгэнт өгүүлсэн.

Тэрээр "Би Хятад орныг байлдан эзэлж, энэ их улсын умарт зүгийн бүх турк туургатныг эрхэндээ оруулж авсныг чиний бие мэдэхгүй байж үл болно хэмээн хоёр улсын зарчмын гол асуудлыг шууд хөндөж тавьжээ.

Энэ нь Чингис хааны хорезмын талаар явуулсан дипломат бодлогын хүчтэй ялалт болсон бөгөөд элч төлөөлөгч худалдаачдаа алуулж хохирч байсан авч, элчин харилцааны алхам тутамд амжилт олсоор байжээ. Тэр үед аль аль талд нь бие биедээ нэвтрэхэд дөхөмтэйг харгалзан худалдаачдыг тагнан туршиж ажил хийлгэж байв. Мөн эсрэг талдаа өөрийн төлөөний татнуултай болохыг зорьж байв.

1218 онд Хорезмын хаан Чингисийн элч Махмудыг Чингисийн ордон дахь өөрийн тагнуул болохыг шаардаж их хөрөнгө мөнгө амлаж байжээ. Чингис хааны Хорезмтай харилцахдаа мөн л газар нутаг, заншил төрхийг сайн мэдэх хуучин тэндхийн харъяат нарыг өргөн ашиглаж байв. Чингис хаан Монгол улсын нутгаар өнгөрөн гарсан эртний Өрнө Дорнын худалдааны замыг өөрийн хяналтанд оруулах бодлогыг явуулж эхэлсэн байна.

Харийн жуулчдын өнгөрөн явах улсын аюулыг сэргийлэн тэднийг бие хамгаалах харуулыг томилсон ба Монголын их зам тэргүүрээр аялан явах харийн хүмүүсийг өөрийн өргөөнд бараалхуулж байх Чингисийн зарлиг гарчээ.

Энэ нь Чингис хаан алс өрнө зүгийг онцлон сонирхож байсны нэгэн илрэл бөгөөд Монголын худалдааг өрнөдөд нэвтрүүлэх, Өрнө дорнын худалдааны харилцааг зүйл бүрээр дэмжин, түүгээр дамжин Монгол улсынхаа нэр хүндийг гадаад орнуудад дэлгэрүүлэх бодлого байлаа. Чингис хаан Хорезм улстай найртай

айлсан суухын төлөө, бусдын газар нутагт шунах хэтийн бодлого тавиагүй мэт харагдаж байлаа.

Гэвч дараа дараагийн хэрэг явдлын өрнөл түүний мөн чанарыг нотлон харуулсан юм. Чингисийн илгээсэн элчийн дагалт 450 худалдаачид Отрар хотод буудаллаж байх үед нь хотын захирагч Иналчук (Кайр хан) тэднийг цөмийг тагнуул хэмээн басамжлан хороож, эд хөрөнгийг нь хураажээ.¹⁷ Энэ бол Хорезмын талаас дипломат ёс, элчин болон худалдааны нэгэнт харилцан тогтсон журам горимыг бүдүүлгээр зөрчсөн хэрэг байв.

Чингис хаан Хорезмд аян дайн хийхийн зайлшгүй ойлгон бэлтгэж байсан бөгөөд Алтан улсын эсрэг явуулах байдлааны ажиглалааг Мухулай цэцэнд даалгаж, Тангадад хийх довтолгооноо ч хойшлуулсан байна.

Чингис хаан дээрх хэрэг явдлыг сонсоод машинд хянуур хандан Сартуулын ханд Ибн Керөжд Багро (Бугуур) тэргүүтэй элчийг илгээж Сартуулын хааныг итгэлийг эвдлээ гэж буруушаагаад Отрарт болсон хэрэг чиний тушаалаар хийгдээгүй бол Иналчүкийг гаргаж өгөж шаардсан байна. Гэтэл хариу өхийн оронд Мухамед шах элчийг алжээ.¹⁸

Нүүц товчооны мэдээгээр Ухуна тэргүүтэй 100 элчийг цаазалсан тухай баримт бас бий. Энэ бүхэн Чингис хааны Хорезмын эсрэг хийх дайны хангалттай шалтаг болжээ. Хорезмд дайтан ороход өөрийн талд зарим томоохон феодалуудыг татан авах, Хорезмын дотоод задрал, эв нэгдэлгүй байдлыг чадамгай ашиглажээ. Чингис хаан Мерв хотын захирагч Мелек, Отрарын Бедр Уд дин зэрэг ноёдтой холбоо тогтоон харилцаж байлаа. Үүгээр Монгол хорезмын элчин харилцаа тасарч Монголын их цэрэг Дундад Азид дайлаар ороход хүргэжээ. Хорезмыг унагаах бүх дайны бэлтгэлийг элчин харилцааны ард бэлтгэж амжсан байна. Хорезмд хийх аян дайн нь зөвхөн энэ бүс нутгаар хязгаарлагдахгүй цаашид өрнө зүгт цонх, гарцтай болоход чухал ач холбогдол нь оршиж байжээ.

Чингис, Хорезмтай л харилцаж байсан мэт харагдавч тэрээр алс өрнөдийн талаарх их бодлогын нэг алхам гэж үзэж Хорезмыг "Алтан аргамж"-аар урхидан хүлж улмаар цэргийн хүчээр шийдвэрлэсэн билээ.

Ишлэл

1. Д.Оссон "История Монголов от Чингиз хана до Тамерлана" т.1, Иркутск, 1937, 127-128 тал
2. Рашид Ад-дин "Сборник летописей", т-1, кн II, 188 тал
3. Д.Оссон "История Монголов...", 127-128 тал
4. МНТ, §254, 256 тал
5. МНТ, §117, 183, 190, 196 тал
6. Рашид Ад-дин, т-1, кн-II, 117 тал
7. Ц.Дамдинсүрэн "Монголын уран зохиолын тойм", УБ, 263-264 тал
8. Ж.Бор. "Монголын улс төрийн гадаад бодлого, дипломатын зарим асуудал", УБ, 1988, 100 тал
9. "Монгол-Татаарууд Ази Европт", УБ, 1984, 97-р тал
10. Д.Кхиукенбаатар The Foreign Policy "Altan Argamj" of Chingis Khaqan – Embassy Relations" (1206-1227), 1992, Taipei, Р.О.С. 2 тал
11. Д.Хуухэнбаатар. "Монгол гүрний элчин харилцаа" (XIII зуун), УБ, 1964, 19 тал
12. В.Бартольд. "Туркестан в эпоху монгольского нашествия", (ПБ, 1900, 423-426 тал)
13. Мөн ном, мөн тал
14. Д.Хуухэнбаатар. "Монгол гүрний элчин харилцаа" (XIII зуун), УБ, 1964, 19 тал
15. Грумм-Гржимайло. "Западная Монголия и Урянхайский край", 1926, т-II, 427 тал
16. Д.Оссон. "История Монголов...", т-1, 127 тал
17. М.И.Иванин. "О военном искусстве завоевателей Монголо-татара" среднеазиатских народов при Чингис хана и Тамерлан", СПб, 1875, 55 тал
18. В.Тизентгаузен. "Сборник материалов относящихся к истории Золотого Орда", т-1, 1889, 7 тал